

## ОЛЛОО ХХК-ИЙН ХУВЬЦААНЫ ТАНИЛЦУУЛГА

### Танилцуулгын эхний хэсэг

#### *1. Үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл, тухайн зах зээлд үнэт цаас гаргагчийн эзлэх байр суурийн талаархи мэдээлэл, судалгаа:*

Оллоо ХХК нь 2004 оноос эхлэн вэб программчлал, онлайн зар сурталчилгаа, үйлчилгээг үзүүлж [www.olloo.mn](http://www.olloo.mn) сайтыг бүтээн интернет хэрэглэгчдийн хамгийн өргөн үйлчлүүлдэг, өөрийн байр сууриа олсон үндэсний тэргүүлэх компани болж чаджээ.

#### **Эрхэм зорилго**

**Олсон амжилтаа улам бэхжүүлж, шинээр гарч буй техник, технологийн дэвшлийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэрэглэгчиддээ чанартай, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх.**

Оллоо ХХК нь нийгэм, цаг үеийн шуурхай шинэлэг мэдээ мэдээлэл, соёл урлаг, уран зохиол, спорт чөлөөт цаг, цаг агаар, ханшийн мэдээлэл, MP3 архив, зурхай, онигоо, гэр бүл эрүүл мэнд, гоо сайхан, хууль эрх зүй, сэтгэл зүй, зургийн цомог, сонжоо зар сурталчилгаа зэрэг арав гаруй салбарт зуу орчим мэдээллийн төрлүүдийг багтаасан монгол хүмүүсийн оюуны хэрэгцээг хангахуйц [www.olloo.mn](http://www.olloo.mn) сайтыг ажиллуулж эхлээд байна.

Одоогоор манай сайтад давхардаагвй тоогоор едер бвр 180 гаруй мянган хэрэглэгч тогтмол орж хэрэгтэй мэдээллээ авдаг бегеед нийт уншигчдын 30 орчим хувийг гадаадад байгаа монголчууд эзэлдэг ба үлдэх хувийг монгол улс дотроос хандсан байдаг. Энэ хандалтын тоо нь өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь бидэнд улам бүр урам зориг оруулж байдаг.

Манай компаний зорилгуудын нэг нь нийт интернэт хэрэглэгчид, түүний дотор гадаад оронд ажиллаж, сурч амьдарч байгаа иргэдэдээ эх орныхоо талаар өргөн мэдээллийг цаг тухайд нь бодитойгоор авах боломж олгох явдал юм. Мөн орон нутгийн ард иргэддээ электрон хэвлэлээр едер бвр шинэ мэдээ мэдээллийг хүргэж, хүмүүсийн интернэтийн хэрэглээг ергежүүлэхийг зорьж байна. Цаашилбал дээр дурьдсанаар интернэтийг ашиглан өөрийн цаг хугацаагаа хэмнэж, хийж байгаа болон хийх ажлаа хялбаршуулах хөдөлмөрийн

бүтээмжээ дээшлүүлэх зэрэг интернэтийн асар их боломжийг ашиглан маш олон зүйлийг бүтээхэд чиглэж байгаа юм.

Бид зөвхөн цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргээд зогсохгүй нийгмийн салбар тус бүртэй холбогдолтой мэдээллийн санг бүрдүүлэх, уншигчдад мэргэжлийн байгууллага хүмүүсийн заавар зөвлөгөөг өгч байх, тэдэнд үнэн зөв бодитой мэдээллийг цаг тухайд нь хүргэж байхыг чармайдаг.

Манай компани нь зөвхөн хэвлэл мэдээлийн сүлжээ байгаад зогсохгүй техник технологийн өндөр хөгжлийг даган орон зай, цаг хугацаанд үл хязгаарлагдах худалдаа арилжааны шинэ хэлбэр болох онлайн худалдааг монголд жинхэнэ утгаар нь хөгжүүлэх үүднээс «Интернэтийн их дэлгүүр»-ийг нээн ажиллуулж эхлээд байна. Энэ нь хэрэглэгч сонирхсон бараа товаараа эндээс илүү хямдаар худалдан авахаас гадна [www.oloo.mn](http://www.oloo.mn) сайтаар дамжуулан бараа бүтээгдэхүүнээ зарж борлуулах, худалдан авагчдынхаа хүрээг тэлэх өргөн боломж нээгдэж байгаа юм.

Бидний эрхэм зорилгын нэг хэсэг болох гадаадад болон хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа иргэддээ монгол улсад өрнөж буй халуун мэдээ мэдээллийг цаг алдалгүй бодитоор хүргэж иргэдийн интернетийн хэрэглээг өргөжүүлэхийг зорин ажиллаж байна.

### **Өнөөдрийг хүртэл бид**

Оллоо ХХК-ийн хамт олон өөрийн салбарын онцлог, эрэлт хэрэгцээг судалж, тэдгээртэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлж ирснээр хэрэглэгчдийн зан төлөв, тэдний хүсч буй мэдээллийг өөрийн хэвлэн нийтлэх бодлоготой уялдуулж ажилласнаар эдүгээ Монголын хамгийн олон уншигчтай вэбсайт болжээ.

### **Компанийн техникийн үзүүлэлт:**

Оллоо ХХК нь 4 rack, 1 Пи Си сервер, 1 хостингтэй нийт 6 сервертэй бөгөөд байршуулалтын хувьд мажикнет дээр 3, Жинет дээр нэг 1-дотоод сүлжээгээ давхар хангадаг, рэйлком дээр 1 тус тус байршиж байна. Linux System бууж программчлалын php, MySQL /бүх subdomain нийлээд 500-600 mb,php зураг нийлээд 10-20 mb/ , html, javascript дээр бичиж байна.

**2. Үнэт цаас гаргагчийн зохион байгуулалт, удирдлагын бүтэц, салбар төлөөлөгчийн газрууд, нэгжийн тухай танилцуулга:**

23 үндсэн ажиллагсадтай, гэрээт 8 мэдээний ажилтан, борлуулалтын 4 менежер зэрэг нийт 35 мэргэжилтнүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үндсэн ажилтнуудыг техник, программ хангамжийн, мэдээ мэдээллийн, борлуулалтын, санхүү бүртгэл, удирдлагын гэсэн үйл ажиллагааны зохион байгуулалттай.

Техник, программ хангамж	Программист-2 Админ-1 Сүлжээний инженер-1 Дизайнер-1 Оператор-1
Мэдээ мэдээлэл	Редактор-1 Сэтгүүлч-3 Зураглаач-1
Борлуулалт	Борлуулалтын ажилтан-1
Санхүү бүртгэл, удирдлага	Гүйцэтгэх захирал-1 Ерөнхий менежер-1 Хуульч-1 Нягтлан бодогч-1 Нярав-1 Туслах ажилтан-2 Жолооч-1

Оллоо ХХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг хавсралтаас үзнэ үү.

**3. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар:**

Оллоо хувьцаат компанийн дүрмийн хуулбарыг хавсаргав.

**4. Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагын шийдвэр. Хэрэв уг үнэт цаасыг гаргах нь тухайн**

**компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохоор бол шийдвэрийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргасан тухай мэдээлэл:**

Оллоо ХХК –ийн Ерөнхий захиралын 2007 оны 7 сарын 20 ны өдрийн ..... тоот тушаал, компанийн тухай хуулийн 43, 44 дүгээр зүйлийн заалтуудыг тус тус үндэслэв.

5. **Сангийн сайдын 2004 оны 12 сарын 22-ны өдрийн 248 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлан, түүний тодруулга бэлтгэх заавар”, Хорооноос баталсан “Үнэт цаас гаргагч, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын тайланд нэмэлт тодруулга бэлтгэх журам”-д заасан нэмэлт тайлбар тодруулгыг бүрэн тусгасан сүүлийн 3 жилийн болон үнэт цаасыг бүртгүүлэхээр зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахын өмнөх улиралын аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан:**

Оллоо ХХК-ийн 2005, 2006, 2007\* онуудын жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажсан тайлангуудыг хавсралт 5-д хавсаргав.

6. **Үнэт цаас гаргагч компани болон түүний толгой, охин компани болон хяналтын багцыг эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй болох талаар банкны өр барагдуулах алба, харилцагч банкны тодорхойлолт:**

Оллоо ХХК нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй бөгөөд харилцагч банкны болон банкны өр барагдуулах албаны тодорхойлолтыг хавсаргав.

7. **Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэн баталгаажуулсан материал:**

Хөрөнгийн үнэлгээний төв ХХК-ийн УБГ дугаар 35/3526, 2545411 тоот регистрийн дугаартай.

Самбуугийн гудамж-11, Улаанбаатар 38, Утас 325127

Оллоо ХХК-ийн бизнесийн үнэлгээний тайланг хавсаргав.

8. **Хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамж төлсөн баримт:**

Хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамжийг төлсөн баримтыг хавсаргав. Хавсралт

## **Танилцуулгын хоёрдахь хэсэг**

### **1. Үнэт цаасны төрөл, хэлбэр:**

- |                               |                |
|-------------------------------|----------------|
| <b>a.</b> Үнэт цаасны төрөл:  | Энгийн хувьцаа |
| <b>b.</b> Үнэт цаасны хэлбэр: | Биет бус       |

### **2. Үнэт цаас эзэмшигчийн эрх:**

МХБ-ээр дамжуулан энгийн хувьцааг худалдан авч өмчилсөн байгууллага, иргэн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 1) Хувьцаагаа хоёрдогч зах зээл дээр худалдах;
- 2) Хувьцаагаа барьцаалах, бэлэглэх;
- 3) Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувь нийлүүлэгч болно.
- 4) Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал зарлах үед Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон “бүртгэх өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.
- 5) Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд, ТУЗ-ийн шийдвэрт заасан хугацаанд олгоогүй бол алданги төлөхийг шаардах эрхтэй.
- 6) Компанийг татан буулгах үед “Компанийн тухай” хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.
- 7) Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
- 8) Хувь нийлүүлэгчдийн хурлаас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
  - a. Нийтлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх;
  - b. Хэлцэл хийхийн өмнө сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25

хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн;

- c. Компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай Компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг баталсан;
- d. Нэг хувь нийлүүлэгч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- e. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 хоног ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.
- f. Хувь нийлүүлэгч нь “Компанийн тухай” хуулийн 66.4-т заасан мэдээлэлтэй танилцах эрхтэй.
- g. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх эрхтэй.

### **3. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график:**

- a. Оллоо ХХК-ийн энгийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахдаа МХБ болон ҮЦТТТХТ ХХК-тай хийсэн гэрээний дагуу үнэт цаасыг биет бус хэлбэрээр хадгалах бөгөөд эхний нийлүүлэлтийг ҮЦТТТХТ ХХК-ийн өөрийн данснаас 10 000 000 ширхэгийг 100 төгрөгийн үнэтэйгээр нийлүүлнэ.
- b. Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд андеррайтер, брокер дилерийн синдикат үүсгэж санал болгох замаар хувьцааг байршуулна.
- c. Анхдагч зах зээл дээр 2007 оны 08 дугаар сарын 22 оос 2010 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хүртэлх хугацаанд байршуулж арилжаална.
- d. Байршуулах үнэ:

Нэгжийн үнэ 100 төгрөг,  
Нийт 1 000 000 000 төгрөг

- e. Үнэт цаасны арилжааны мэдээг Оллоо ХХК-ийн [www.olloo.mn](http://www.olloo.mn) болон МХБ-ийн вэбсайтаас ([www.mse.mn](http://www.mse.mn)) авч болно. Түүнчлэн өөрийн харьяа брокер, дилерийн компаниуд болон Хөрөнгө оруулалтын зөвлөх СИ СИ ПИ ХХК-иас ([www.ccp.mn](http://www.ccp.mn)) арилжааны мэдээллийг авч болно.

**4. Урьд үнэт цаас гаргаж байсан эсэх, үнэт цаасны нэр төрөл, гаргасан огноо, нийт хэмжээ, төлөгдөх буюу төлөгдсөн хэмжээ, өрийн бичиг гаргасан бол үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулж байсан тухай үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагын тодорхойлолт:**

- a. Оллоо ХХК нь урьд өмнө нь өрийн бичиг болон энгийн хувьцааг гаргаж байгаагүй болно.

**5. Үнэт цаас гаргах замаар хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах төсөл, эдийн засгийн үр ашгийн тооцоо:**

- a. Одоогийн явуулж буй үйл ажиллагаагаа сайжруулахын тулд хэд хэдэн стратегийн түнш, хөрөнгө оруулагч нартай хамтарч бизнесээ явуулахын тулд өөрийн эзэмшлийн хувьцаагаа задалж олон нийтэд санал болгон арилжаалах тул төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоо байгүй.
- b. 2007 оноос цаашид хэрэгжүүлэх дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хавсаргав.

**6. Үнэт цаасыг арилжаалахад санал болгох хүрээ:**

- a. Дотоодын томоохон хөрөнгө оруулагч нар авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.
- b. СИ СИ ПИ ХХК-ийн хөрөнгө оруулагч нарт санал болгосон.
- c. Хувьцааг Оллоо ХХК-ийн [www.olloo.mn](http://www.olloo.mn) сайт дээр байрлуулах, олон нийтийн радио телевиз, өдөр тутмын сонингуудаар дамжуулан ард иргэд болон санхүүгийн байгууллагуудад хувьцааны тухай цуврал хичээлийг бусад ҮЦЗЗ-ийг зохицуулагч болон оролцогч байгууллагуудтай хамтран зохион байгуулж оролцоно,

**7. Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ:**

Оллоо энгийн хувьцааг худалдаж авснаар хөрөнгө оруулагчид дараах зүйлүүд дээр анхаарч үзнэ үү.

Доор дурдсан эрсдлийн хүчин зүйлүүдээс хамааран компани төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх магадлалтай. Эдгээрт:

- i. Монгол улсын эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдал
- ii. Өрсөлдөгчдийн үйл ажиллагаа компанийн бизнест нөлөөлөх
- iii. Хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүд

Ирээдүйн орлогод нөлөөлөх эрсдлийг Оллоо ХХК өөрийн эрсдлийн бодлогыг хэрэгжүүлж түүнээс зайлсхийх эсвэл багасгаж чадах ч компанийн үйл ажиллагаанаас үл хамааран учрах эрсдлийн хүчин зүйлүүдээс 100 хувь зайлсхийж чадахгүй.

***Монгол улсын эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдал:***

Монгол улс 2006 онд ДНБ 8.3 хувь өссөн бөгөөд сүүлийн жилүүдэд эдийн засгийн салбар бүрт өсөлт ажиглагдаж байна. Эдийн засгийн өсөлтийн таамаглагдаагүй бууралт, улс төрийн тогтворгүй байдал нь хүн амын худалдан авах чадварт сөргөөр нөлөөлж ирээдүйн орлого таамаглаж байснаас бага болох магадлалтай байна. Эдийн засгийн уналттай холбоотой эрсдэлийг бууруулахын тулд компани тулгарч буй эрсдлийг тархаахын тулд шинэ зах зээл болон бүтээгдэхүүний салбарт нэвтрэн орсоор байх болно.

***Компани үйл ажиллагаагаа хэвийн нь явуулж чадахгүй байх:***

Компанийн хүний нөөцийн стратегийн төлөвлөгөө нь байгууллагыг чадвартай, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, ажлыг удирдан зохион байгуулах, ажилтнуудын хувийн чадварыг дээд зэргээр ашиглах, байгууллагын өөрчлөлт хөгжлийн бодлогод нийцүүлэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, удирдах ба үйлдвэрийн ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.

***Өрсөлдөгчдийн үйл ажиллагаа компанийн бизнест нөлөөлөх:***

Өрсөлдөгч нартай өрсөлдөхүйц үнэ, чанараар өрсөлдөнө. Зах зээлд хэрэгцээт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлж, хүчин чадлаа нэмэгдүүлнэ.

***Хууль эрх зүйн өөрчлөлтүүд:***

Татварын хэмжээнд өөрчлөлт орох, гэх мэт эрх зүйн өөрчлөлтүүд компанийн үйл ажиллагаанд эсрэгээр нөлөөлж болно. Гэвч 2007 оноос аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, нэмүү өртгийн албан татварын хуульд өөрчлөлт орсон бөгөөд компани ойрын хугацаанд татвар өөрчлөгдөхгүй гэж үзэж байна.

***Интернетийн оролтын үнийн өсөлт:***

Нийлүүлэгч нартайгаа урт удаан хугацааны нягт харилцааг тогтоож ажиллана. Жилийн гэрээг урьдчилан хийдэг нь үнийн өсөлтөөс сэргийлэх бодлогын нэг хэсэг билээ.



**8. Үнэт цаасыг андеррайтераар дамжуулан анхдагч зах зээлд худалдахаар төлөвлөж байгаа бол байгуулах гэрээний төсөл, өөрөө анхдагч зах зээлд худалдах бол мэдээллийг нийтэд сурталчлах журам, төлөвлөгөө:**

Оллоо ХХК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр олон нийтэд санал болгохоос хоёр долоо хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайн хувьцааг гаргах өдөр болон бусад нөхцлийн тухай мэдээлнэ.

Мэдээллийг олон нийтэд хүргэхдээ маркетингийн үйл ажиллагааг идэвхижүүлэн доорхи үе шатуудаар дараалан арга хэмжээ авна.

- Хэвлэлийн бага хурал
  - ◆ MN25 өнөөдөр хэвлэл мэдээллийн албатай хамтран хэвлэлийн бага хурал хийнэ.
- Олон нийтэд санал болгох

	Мэдээллийн хэрэгслийн нэр	Сурталчилгааны давтамж	Бусад тайлбар
1	Өдрийн сонин	7 хоногт 3 удаа	1 удаад 27 000₮ 1/8 нүүр
2	Өнөөдөр сонин	7 хоногт 3 удаа	1 удаад 25 000₮ 1/8 нүүр
3	МТВ	7 хоногт 2 удаа	1 удаад 90 000₮
4	TV9	7 хоногт 2 удаа	1 удаад 45 000₮
5	FM Элгэн нутаг	7 хоногт өдөр бүр	1 удаад 2 500₮
6	FM-101.7	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
7	FM 102.5	7 хоногт өдөр бүр	1 удаад 3500₮
8	FM-104.5	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
9	Монголын Радио	7 хоногт өдөр бүр	1 удаад 3500₮
10	FM-98.9	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
11	FM-100.1	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮
12	FM-107.5	7 хоногт өдөр бүр	1 удаад 3 500₮

- Хөрөнгийн биржийн мэдээллийн албатай хамтран ажиллах,
  - ◆ Өдөр тутмын сонины сэтгүүлчидэй уулзах
  - ◆ Хөрөнгийн зах зээл сэтгүүлд зар тавих
  - ◆ Хөрөнгийн бирж болон СИ СИ ПИ ХХК-ийн цахим хуудас дээр аноунс хийж тавих
- Арилжааны банкуудад санал болгох
  - ◆ Хөрөнгө оруулагч нарт зориулсан тусгай presentation болон танилцуулга брошур бэлдэн танилцуулах,
- Томоохон хадгаламж эзэмшигч нарт
  - ◆ Хувьцааны танилцуулга, брошур бэлдэн танилцуулах,
- Гадаадын хөрөнгө оруулагчдад
  - ◆ Англи хэл дээр тусгай presentation болон танилцуулга брошур бэлдэн танилцуулах,

## **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.3, 7.4-Д ЗААСАН МЭДЭЭЛЭЛ**

### **1. Үнэт цаас гарагчийн нэр, оршин байгаа хаяг:**

Оллоо ХХК, Соёлын төв өргөө,  
Сүхбаатар дүүрэг, 1101-1105 тоот  
Утас: 976-11-331580  
Факс: 976-11-319081  
Имайл: [INFO@OLLOO.MN](mailto:INFO@OLLOO.MN)

### **2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар:**

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав. Хавсралт 9

### **3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэмшдэг этгээдийн талаарх мэдээлэл:**

#	Овог Нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны %
1	Ц. Энхцэцэг	Ерөнхий захирал	100%

### **4. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь уг үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг эзэмшдэг бол түүний хувь хэмжээ:**

#	Овог Нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны %
1	Ц. Энхцэцэг	Ерөнхий захирал	100%

### **5. Үнэт цаас гаргагчийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан санхүүгийн тайлан, өр, зээлийн талаархи мэдээ:**

#### **Санхүүгийн үзүүлэлтүүд**

Компанийн Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлангуудын хураангуйг доорхи хүснэгтэд харуулав.

#### **Хүснэгт**

## Тайлан тэнцэл

	/Мянган төгрөг/		
	2005	2006	2007. II
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>440</b>	<b>2,295</b>	<b>6,291</b>
Мөнгөн хөрөнгө	440	2,295	3,760
Авлага		6,733	2,523
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>1,385,332</b>	<b>21,914</b>	<b>999,309</b>
Тавилга, эд хогшил	19,147	28,406	28,599
Элэгдэл	(1,892)	(6,526)	(9,004)
Биет бус хөрөнгө	37	34	999,309
<b>Нийт хөрөнгө</b>	<b>17,731</b>	<b>24,210</b>	<b>1,005,600</b>
<b>Эх үүсвэр</b>			
<b>Нийт өр төлбөр</b>	<b>27,266</b>	<b>33,799</b>	<b>35,550</b>
Дансны өглөг	27,000	29,805	29,812
ХАОАТ-ын өглөг	28	89	922
НӨАТ-ын өглөг	(41)	3,136	2,742
ЭМНД-ын шимтгэл	280	767	2,074
<b>Эздийн өмч</b>	<b>(9,535)</b>	<b>(9,588)</b>	<b>970,050</b>
Хувийн	5,000	5,000	5,000
Дахин үнэлгээний нөөц			979,680
Хуримтлагдсан ашиг/алдагдал	(14,535)	(14,588)	
Тайлангийн үеийн	(14,535)	(53)	(42)
Өмнөх үеийн	0	(14,535)	(14,588)
<b>Нийт эх үүсвэр</b>	<b>17,731</b>	<b>24,210</b>	<b>1,005,600</b>

2005 оны эцсээс 2007 оны 2 дугаар улирлыг хүртлэх хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ 56 дахин өсчээ. Дансны өглөгийн хувьд богино хугацаат нийгмийн даатгалын болон хүн амын орлогын албан татварын өглөг байгаа бөгөөд өр төлбөр эзэмшигчдийн өмчийн 0.47 хувийг эзэлж байгаа нь Оллоо ХХК өр төлбөрийн хувьд бага байна. Оллоо ХХК нь богино хугацаанд борлуулалтаа нэмэгдүүлэн, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлуудаа хэмнэж чадсанаар ашигт ажиллагаагаа нэмэгдүүлсэн юм.

**Орлого үр дүнгийн тайлан**

	/Мянган төгрөг/		
	2005	2006	2007. II
Нийт борлуулалт	7,653	61,168	51,495
Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг	17,416	44,871	38,706
<b>Нийт ашиг</b>	<b>(9,763)</b>	<b>16,297</b>	<b>12,789</b>
Үйл ажиллагааны зардал	4,783	6,000	12,829
<b>Үйл ажиллагааны ашиг</b>	<b>(14,546)</b>	<b>10,296</b>	<b>(41)</b>
Үйл ажиллагааны бус орлого	12	0	0
Үйл ажиллагааны бус зардал	0	10,340	18
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>(14,534)</b>	<b>(44)</b>	<b>(42)</b>
Орлогын татвар			
<b>Цэвэр ашиг</b>	<b>(14,534)</b>	<b>(44)</b>	<b>(42)</b>

2007 оны 2 дугаар улирлын байдлаар борлуулсан бүтээгдэхүүний өртөг нийт борлуулалтын 76 орчим хувийг эзэлж байна. Нийт зардлын 23 орчим хувийг ажиллагсдын цалин, хөдөлмөрийн хөлс болон боловсон хүчин бэлтгэх зардал, 9 хувийг шуудан холбооны зардал, 49 хувийг богино хугацаат зээлийн хүүгийн зардал тус тус эзэлж байна.

**6. Үнэт цаасыг арилжаалахад зуучлах мэргэжлийн байгууллагын тухай мэдээлэл:**

Үнэт цаасыг арилжаалахад зуучлах мэргэжлийн байгууллага нь СИ СИ ПИ ХХК хувьцаа гаргахад ерөнхий хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг үзүүлж байна.

СИ СИ ПИ ХХК нь үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргагчдыг шинээр үнэт цаас гаргахад зах зээлд шаардагдах шинжилгээ хийх, хяналт явуулах, зөвөлгөө өгөх, зуучлан борлуулах, худалдан авах, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох зэрэг үйл ажиллагааг хийж гүйцэтгэдэг.

Монгол улсад хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа цаашлаад санхүүгийн зөвлөх компанийн орон зай дутагдаж байгаа өнөө үед цаг үеэ олсон, шинэлэг, ур чадвар бүхий Хөрөнгө оруулалтын зөвлөх Си Си Пи ХХК (ССР) 2006 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

ССР нь дотоодын компаниудад үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Монголын болон олон улсын хөрөнгийн биржээс санхүүжихэд зөвлөгөө өгч туслахын зэрэгцээ олон улсын болон дотоодын стратегийн түншүүдтэйгээ хамтран компаниудад мэргэжлийн санхүүгийн үйлчилгээг хүргэж харилцагчдынхаа хөрөнгийг өсгөхөд харамгүй туслалцаа үзүүлэхэд бэлэн байна.

Бид гадаад, дотоодод хөрөнгө оруулалтын банк, стратегийн зөвлөхийн чиглэлээр ажиллаж байсан нэр хүндтэй их сургууль төгссөн чадварлаг багийг бүрдүүлэн ажиллаж байна.

## **Бидний зорилго**

ССР нь Монголын өсч яваа эдийн засгийн хэрэгцээг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг хуваарилах, удирдах ажлыг гүйцэтгэхэд ерөнхий санхүүгийн зөвлөхөөр ажиллах болно. ССР ХХК-ийн хэтийн зорилго бол санхүүгийн зөвлөгөө, сангийн удирдлага, үнэт цаасны андеррайтинг, байршуулалт зэрэг санхүүгийн зөвлөгөөний үзүүлдэг тэргүүлэгч компани болох явдал юм. ССР нь харилцагч нартаа ашигтай санхүүгийн шийдлүүдийг мэргэжлийн өндөр түвшинд хүргэхэд зуучлан зөвлөх болно.

ССР-ийн зорилго дотоодын компаниудыг дэлхийн түвшний байгууллага болоход нь өсөлт, хөгжлийнхөө хэрэгцээг удирдах шинэлэг, үр ашигтай санхүүжилтийн шийдлүүдийг хүргэж туслах явдал юм.

ССР монгол улсын эдийн засагт оюуны хөрөнгө оруулалтыг түлхүү хийж өндөр хувь нэмэр оруулах төдийгүй нийт бизнесийн хүрээнийхний өсөлт, хөгжилтөд ч хувь нэмрээ оруулах болно.

## **Бидний туршлага**

ССР нь байгууллагын бонд андеррайтинг, үнэт цаасны зах зээлийн төрөл бүрийн хэрэгслүүдийн судалгаа, эдийн засгийн үндэслэл гаргах, компанийн санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааг нь дүгнэх, үнэт цаас болон хөрөнгө оруулалтын стратеги, стратегийн өсөлт хөгжил, ашгийн өсөлтийн удирдлагын чиглэлээр зөвлөх үйлчилгээг үзүүлж байсан туршлагатай

Ажлын туршлагын хувьд Анод банкинд Монголын Үнэт Цаасны хорооноос (одоогийн Санхүүгийн зохицуулах хороо) андеррайтингийн эрхийн лицензийг авч анхны хөрөнгө оруулалтын банкны суурийг тавиж байсан, MCS Электроникс ХХК болон Говь ХК, Анод Банкны нийт 5.6 тэрбум төгрөгийн бондыг хөрөнгийн зах зээл дээр гаргах ажлыг амжилттай удирдаж байсан. МСС ХХК-ийн андеррайтингийн эрхийн лицензийг авч байсан.

Канад улсын Айвенхоу Майнз ХХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах тухай, Айвенхоу Майнзын хувьцааг хөрвүүлж MDR болгон гаргах төслийн удирдагчаар ажиллаж байсан. 2006 оны 11 сард Техник Импорт ХК-д санхүүгийн зөвлөхөөр ажиллаж нийт 560 сая төгрөгийн санхүүжилтын асуудлыг шийдвэрлэсэн.

Монгол улсын үнэт цаасны тухай хууль болон

Санхүүгийн Зохицуулах Хорооны

36 тоот тогтоолын хавсралт журмын дагуу

Оллоо ХХК-ийн бэлтгэсэн танилцуулга

2003-2006 онуудад Говь ХК, Сүү ХК, Хадгаламжийн банк ХХК зэрэг томоохон төрийн өмчийн газруудын хувьчлалд зөвөлгөө өгч төслийг удирдан оролцож байсан.

2007 оны 6 сард Юнигаз ХХК-ийн 700 000 ам.долларын биет бондыг гаргасан.

**7. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл:**

Бусадтай байгуулсан их хэмжээний гэрээ хэлцэл байхгүй болно.